# БАРААНЫ АНГИЛАЛ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Ц.УРАНТУУЛЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин: Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 2. Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх** | | | | | | | |
| 1 | Барааны ангилал | Хэрэгжилт, гүйцэтгэ-лээр | 100 | 1.Тарифын болон тарифын бус зохицуулалт, татварын чөлөөлөлттэй холбоотой эрх зүйн актын төсөлд санал өгч, барааны ангиллын кодыг тодорхойлсон байна. | 1. ГТГТТХ-ийн 38.1.20 дахь заалтын дагуу [redacted] үйлдвэрлэл, технологийн паркийн төслийг хэрэгжүүлэх [redacted]" ХХК нь татвараас чөлөөлөгдөн импортлох тоног төхөөрөмж, эд анги, бараа материал нийт 611 нэр төрлийн барааны ангиллын кодыг тодорхойлуулах хүсэлт ирүүлснийг судлан жагсаалтын ширэм, хорголжны үйлдвэрийн нийт 286 тоног төхөөрөмж, бараа материалаас 107 барааны ангиллын кодыг тодорхойлон 159 барааны нэмэлт тайлбар, тодруулга авах асуултыг боловсруулан цахим хаягаар хүргүүлсэн. Мөн нүүрс, коксны үйлдвэрийн тоног төхөөрөмжийн талаар нэмэлт тайлбар, тодруулга авах асуултыг боловсруулан хүргүүлсний дагуу ирүүлсэн тайлбарыг судлан 57 барааны ангиллын кодыг тодорхойлох ажлыг хийсэн.<br>[redacted]ХК нь 5-р сарын 18, 06-р сарын 04-ний өдрүүдэд нүүрс, коксны үйлдвэрийн тоног төхөөрөмж, эд анги, хийц хэсэглэл, 06-р сарын 05, 07-ны өдрүүдэд хорголж, ширэм боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж, эд анги, хийцийн жагсаалтыг дахин шинэчлэн ирүүлсэн. Мөн ЗГ-ын 05-р сарын 01-ний өдрийн "Албан татвар төлөх хугацааг сунгах тухай" 191 дүгээр тогтоолоор зөвхөн тоног төхөөрөмж болон түүний иж бүрдэлд ногдуулах татварыг хойшлуулах буюу хуулийн заалт болон тогтоолд заасан барааны нэр төрөл зөрүүтэйгээс ангиллын кодыг тодорхойлоход хүндрэлтэй байгаа талаар чиглэл авах хүсэлтийг СЯ-нд 2024.06.04-ний өдрийн 02/2254 тоот албан бичгийг хүргүүлж чиглэл авч ажилласан. Тус компани нь эхний ээлжинд зөвхөн коксын үйлдвэрийн тоног төхөөрөмж, бараа материалын худалдан авалтыг хийхээр болсон гэсэн тайлбарыг ирүүлсэн тул нийт 185 нэр төрлийн барааны ангиллын кодыг тодорхойлж 2024.07.24-ний 02/2992 тоот албан бичгээр СЯ-нд хариуг хүргүүлсэн.<br>2. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас насанд хүрэгчдийн бараа бүтээгдэхүүний ангиллын код болон хилийн хяналт шалгалтад хамрагддаг эсэх талаар мэдээлэл авах хүсэлтийг ирүүлсний | 01.01-12.31 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дагуу холбогдох мэргэжилтнээс нэмэлт тодруулгыг авч, [redacted] ХХК насанд хүрэгчдийн барааг 2021-2023 онуудад импортолсон эсэх талаар гаалийн мэдүүлгийн сангаас шүүж үзэн 2023 оны 8-р сарын 28-ны өдрийн [redacted] тоот мэдүүлгээр нэг удаа бүрдүүлэлт хийсэн, харин 2021 болон 2022 онд тус компаний нэр дээр энэ төрлийн барааны гаалийн бүрдүүлэлт байхгүй, мөн эмнэлгийн хэрэгслийн жагсаалт байдаггүйгээс гаалийн бүрдүүлэлт хийхэд хүндрэл гардаг талаар 2024.01.17-ны өдрийн 02-2.1/249 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>3. ХХААХҮЯ-наас 2024 оны 04-р сарын 19-ний өдрийн "Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай" хуулийн хүрээнд ЗГ-ын тогтоолоор батлагдах мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт, улаанбуудайн гурил нийт 16 нэр төрлийн барааны жагсаалт ирүүлснийи ангиллын кодыг хянаж, хуулийн заалтад хамаарахгүй 5 барааг хасах саналыг өгсөн. Энэ тогтоолын төсөл нь ЗГ-ын 2024 оны 05-р сарын 01-ний өдрийн 180 дугаар тогтоолоор батлагдсан.<br>4.СЯ-наас ЗГ-ын 2016 оны 198 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх сэргээгдэх эрчим хүчний судалгаа, шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэгийн жагсаалт"-д сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хослон ажиллах эрчим хүч хуримтлуурыг нэмж тусгахаар ирүүлсэн ЗГ-ын тогтоолын төсөлтэй танилцан, 6 барааны ангиллын кодыг тодорхойлон 2024.10.15-ны өдрийн 01/4213 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн. Энэ тогтоолын төсөл нь ЗГ-ын 2024 оны 10-р сарын 30-ны өдрийн 150 дугаар тогтоолоор батлагдсан.<br>5.СЯ-наас ЗГ-ын 2019 оны "Жагсаалт батлах тухай" 247 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэлийн жагсаалт"-д нэмэлт оруулах нийт 364 барааны жагсаалтыг ирүүлсэн. Дээрх тогтоолын хүчинтэй хугацаа нь 2024 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болно. СЯ-наас зөвхөн нэмэлт оруулах спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэглэлийн жагсаалтыг ирүүлсэн тул ЗГ-ын тогтоолын төслийг жагсаалтын хамт шинэчлэн ирүүлэх саналтай талаар хариуг хүргүүлэхээр бэлтгэж байна. | | |
| 2 | Барааны ангилал | Хэрэгжилт, гүйцэтгэ-лээр | 90 | Шаардлагатай тохиолдолд үндэсний код, хэмжих нэгжид нэмэлт, өөрчлөлт оруулсан байна | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас хайлуур жоншны стандартыг шинэчилсэн, "Төмрийн хүдэр, баяжмал болон төмрийн бүтээгдэхүүн. Техникийн шаардлага MNS 7017:2023" стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн С/39 дүгээр тушаалаар шинээр батлуулсантай холбоотойгоор төмрийн хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний үндэсний кодыг шинэчлэн боловсруулах хүсэлт ирүүлснийг судалж үзэн төмрийн баяжмалыг боловсруулалтын түвшингээр нь үндэсний кодын задаргаа хийх тушаалын төслийг боловсруулсан. Үндэсний код шинэчлэн боловсруулах хүрээнд стандартуудыг судалж үзэхэд "Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба | 01.01-12.31 | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал MNS 6249:2011" гэсэн Монгол Улсын стандарт хүчинтэй мөрдөгдөж байсан тул дээрх 2 стандартын төмрийн хүдэр, баяжмал, төмрийн бүтээгдэхүүний тодорхойлолт, ангилал нь хоорондоо нийцэхгүй байгаагаас үндэсний код боловсруулахад хүндрэлтэй байгааг шийдвэрлэж өгөх хүсэлтийг 2024.04.12-ны өдрийн 02-2/1417 тоот албан бичгээр хүргүүлсэн, одоогоор хариу ирүүлээгүй байна. | | |
| 3 | Барааны ангилал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 95 | Уялдуулсан системийн хорооны шийдвэрийг орчуулан шийдвэрийн сан баяжуулсан байна. | УСХ-ны шийдвэрүүдээс 21 шийдвэрийг сонгон орчуулж, CAIS програмын УСХ-ны шийдвэрийн санд оруулан ГУБ нар тодорхой барааны ангиллын талаарх мэдээллийг авах боломжийг бүрдүүлсэн. | 01.01-12.31 | 85 |
| 4 | Барааны ангилал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 | Харьяа гаалийн газар, хороодыг барааны ангилалтай холбоотой удирдамж чиглэлээр хангах, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулсан байна. | Харьяа гаалийн газар, хороодыг барааны ангилалтай холбоотой чиглэлээр хангах, зөвлөгөө өгөх ажлын хүрээнд дараах ажлыг хэрэгжүүлж ажилласан.<br>Үүнд:<br>- Бүрдүүлэлтийн цахим төвд ГЕГ-аас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, нэг төрлийн барааг өөр өөр ангиллын кодод хамааруулан ангилах, татварыг багаар төлөх боломжийг олгосон алдааг дахин гаргахгүй байх, ялангуяа Зүйл 90.18-д ангилан мэдүүлсэн барааны ангиллын кодыг нягтлан шалгах чиглэлийг 2024.03.12-ны өдрийн 02-2.1/047 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>- 2024 оны 1 дүгээр улиралд бүрдүүлэлт хийгдсэн мэдүүлгүүдээс ялгавартай татвартай барааг бага татвартай бараагаар мэдүүлэх магадлал бүхий 6810.99.00, 7019.80.00, 9018.39.00, 9018.90.00 кодуудаар ангилж бүрдүүлэлт хийгдсэн мэдүүлгүүдийг нягтлан шалгаж, БЦТ-ийн бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУАБ, ГУБ нарт 2024 оны 05-р сарын 02-ны өдөр зохион байгуулсан сургалтын үеэр алдаатай хийгдсэн мэдүүлгүүд болон цаашид анхаарах асуудлаар чиглэл, зөвлөмжийг өгсөн. Өгсөн чиглэл зөвлөмжийн дагуу "гааль зөвшөөрөв" төлвөөс буцаан 6 мэдүүлгийн 19 барааны ангиллын кодыг засварлаж, нийт 6,9 сая төгрөгийн татварыг нэмж төлүүлсэн.<br>- Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтад 2024 оны 04-р сарын 05, 25-ны өдрүүдэд нийт 112 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнд барааны ангилал болон анхаарах асуудлын талаар сургалт хийсэн.<br>- Тус хэлтсээс БЦТ-ийн ГУБ нарыг хамруулан зохион байгуулсан "Гаалийн үнэлгээний ахисан шатны сургалт"-д ДГБ-ын Уялдуулсан системийн хороо, хорооноос гаргасан ангиллын шийдвэрүүдийн талаарх танилцуулгыг бэлтгэн танилцуулсан. | 01.01-12.31 | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Барааны ангилал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Их өгөгдлийг ашиглан хиймэл оюун ухааны тусламжтайгаар барааны ангиллын код тодорхойлоход лавлагаа болгон ашиглах платформын туршилт хийх бодлогын даалгавар боловсруулсан байна. | Платформыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болох ДГБ-ын BACUDA хөтөлбөрийн Их өгөгдлийг ашиглан хиймэл оюун ухааны тусламжтайгаар барааны ангиллын код тодорхойлоход лавлагаа болгон ашиглах платформ (AI Based HS Code recommendation system)-ыг нэвтрүүлэхэд дэмжлэг туслалцаа авч, хамтран ажиллах хүсэлтэй байгаа талаар ДГБ-д уламжлуулахаар ГХАХ-т 2024.04.19-ний өдрийн 02-2.1/80 тоот дотоод зурвасыг хүргүүлсэн, одоогоор хариу ирүүлээгүй байна. Мэдээллийн технологийн төвийн ГУАБ Н.Мөнхзул платформыг хийж байна. Энэ ажил дуусахаар туршилтыг хийнэ. | 01.01-12.31 | 85 |
| **Зорилт 3: Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх** | | | | | | | |
| 1 | Ангилалтай холбоотой маргаан, гомдлын шийдвэрлэлт, хяналт тавьсан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 | Барааны ангилалтай холбоотой ирүүлсэн санал, хүсэлт болон газар, хороодын даргын шийдвэрт гаргасан гомдол, маргааныг шийдвэрлэх, шийдвэрийн цахим санг баяжуулсан байна. | 1. Төрийн байгууллагаас 1 хүсэлт, 1 санал авах албан бичиг, аж ахуйн нэгжээс ирүүлсэн 3 хүсэлтийг судлан хариуг хүргүүлсэн. Үүнд:<br>- Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу барилгын дотор орчинд хэрэглэдэг 11 нэр төрлийн 82 барааны ангиллын кодыг тодорхойлон эдгээр барааны 2020-2023 онуудын статистик мэдээг гаргуулахаар 2024.04.08-ны өдрийн 02-2.1/72 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>- СЯ-наас ЗГ-ын 2011 оны "Аргачлал батлах тухай" 193 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ашигт малтмалын хүдэр, баяжмал, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд тавигдах шаардлага, ангилал, тооцох үндсэн зарчим, аргачлал"-д өөрчлөлт оруулах, ЗГ-ын 2015 оны 502 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ашигт малтмалын эцсийн бүтээгдэхүүний жагсаалт"-д өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөлд тус тус санал авахаар албан бичиг ирүүлсний дагуу ГТЛ-оос дотоод зурвасаар саналыг нь авч нэгтгэн төмрийн бүтээгдэхүүн болох ангижруулсан төмөр, хорголж, хайлуур жоншны ангиллын кодыг тодорхойлон 2024.02.01-ний өдрийн 01/432 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>- [redacted]аас ирүүлсэн хүсэлтийн дагуу Япон улсад үйлдвэрлэсэн эмийн бодис агуулаагүй, жижиг соронзтой, арьсанд нааж хэрэглэдэг "хуянгийн наалт" гэх барааны ангиллын кодыг тодорхойлон 2024.05.16-ны өдрийн 02-2/1949 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>- [redacted]аас ирүүлсэн 5 нэр төрлийн зүрхний мэс заслын [redacted]гэх барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлтийг дахин ирүүлснийг судлан үзэж бараа нь улсын хилээр орсон, гаалийн байгууллагад бараагаа мэдүүлсэн тул хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй талаар 2024.09.16-ны өдрийн 02-2.1/3742 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 01.01-12.31 | 95 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | - Мөн “[redacted] “[redacted]” гэх барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлуулах хүсэлт ирүүлснийг судалж үзэн 9021.90.00 кодод ангилагдах талаарх хариуг 2024.10.22-ны өдрийн 02-2.1/4319 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>2. ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс ирүүлсэн 10 хүсэлтийг судлан хариуг хүргүүлж ажилласан. Үүнд:<br>- ДХШХ-ээс “[redacted]” ХХК-ийн 2019-2021 онуудад бүрдүүлэлт хийгдсэн 12 мэдүүлгийн барааны ангиллын кодын үнэн зөвийг нягталж ирүүлэх хүсэлт ирүүлснийг гадаад худалдааны бичиг баримт болон бараатай нь тулган шалгаж тодорхойлох боломжтой гэсэн хариуг 2024.01.03-ны өдрийн 02-2.1/01 тоот дотоод зурвасаар өгсөн.<br>- ХХ-ээс ЗГ-ын тогтоолоор батлагдах “Бүтээгдэхүүнийг тохирлын баталгаатайгаар зах зээлд нийлүүлэх, улсын хилээр нэвтрүүлэх журам”, “Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-ын төслийг ирүүлсэнтэй танилцан журмын төслийн найруулга, утга санаатай холбоотой 4 санал, ирүүлсэн жагсаалт нь ЗГ-ын 2018 оны 291 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан жагсаалт тул одоогийн байдлаар ангиллын код, барааны нэршлийг нягтлан шалгаж санал өгөх боломжгүй, бусад төрийн байгууллагуудаас жагсаалтад оруулах санал өгч жагсаалтыг шинэчилсний дараа барааны ангиллын кодын талаас санал өгөх боломжтой талаарх хариуг 2024.01.10-ны өдрийн 02-2.1/08 тоот дотоод зурвасаар өгсөн.<br>- ГХАХ-ээс ОХУ-ын Холбооны гаалийн албаны “тээврийн хэрэгслийн хамгаалалтын бүс” гэх барааны ангиллын байр суурь, холбогдох мэдээллийг ирүүлсэнтэй танилцан УСХ-ны 2024 оны 03-р сарын 6-15-ны хооронд болох 73 дугаар хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад тээврийн хэрэгслийн хамгаалалтын бүсний ангиллын асуудал тусгагдсан, энэ асуудлыг судалж байгаа талаарх хариуг 2024.02.16-ны өдрийн 02-2.1/027 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн. Гэвч дахин дотоод зурвас ирүүлсэн тул 8708.21.00, 9401.99.00 кодуудад ангилан бүрдүүлэлт хийж байгаа талаарх тайлбарыг 2024.06.05-ны өдрийн 02-2.1/108 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>- БДШГ-аас ирүүлсэн дотоод зурвасын дагуу газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн болох нафта, алкилат, хөнгөн нэрлэгийн бусад бүтээгдэхүүн, хүнд фракцын дизелийн түлшний “Үндэсний кодод оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай” ГЕГ-ын даргын 2021 оны А/171 дүгээр тушаал, тушаалын нөлөөллийн шинжилгээний танилцуулга, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас уг тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэсэн талаарх албан бичгийн хуулбарыг 2024.04.03-ны өдрийн 02-2.1/70 тоот дотоод зурвасын хамт хүргүүлсэн.<br>- ХХ-ээс “Санчир Ундрах” ХХК-ийн 05-2231003-24-I30002, 05-2231003-24-I30264 тоот мэдүүлгийн “амплатцер”, “судас бөглөгч” гэх 2 барааны | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ангиллын кодыг БЦТ-өөс засуулахаар буцаасантай холбоотой тайлбар авахаар ирүүлсний дагуу барааны ангиллын кодын үндэслэл, уг бараануудтай холбоотой өгсөн чиглэлийн талаар 2024.06.07-ны өдрийн 02-2.1/114 тоот дотоод зурвасаар өгсөн.<br>- ГХАХ-ээс ОХУ-ын Холбооны гаалийн албаны “витамин агуулсан” Канефрон Н, Синупрет гэх эмийн бүтээгдэхүүний ангиллын байр суурь, холбогдох мэдээлэлтэй танилцаад витамин агуулсан дээрх 2 нэр төрлийн эмийг монголын гаалийн байгууллага 3004.90.90 кодод ангилан гаалийн бүрдүүлэлтийг хийж байгаа талаар 2024.08.22-ны 02-2.1/151 тоот дотоод зурвасаар хариу өгсөн.<br>- ХБГ-аас [redacted]-ийн импортлон 12-2201003-24-I30075 тоот мэдүүлгээр “тоглоомын зориулалттай буу” гэж мэдүүлсэн барааны ангиллын кодыг тодорхойлуулахаар дотоод зурвас ирүүлснийг судлаж үзэн 9304.00.00 кодод ангилагдах талаар 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 02-2.1/2987 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн бараатай ижил, мөн тус хэлтсээс уг компанийн импортолсон бараатай холбоотой асуудлаар өмнө нь дотоод зурвас хүргүүлсэн гэсэн хариуг 2024.08.30-ны 02-2.1/155 тоот дотоод зурвасаар өгсөн.<br>- ГТЛ-оос [redacted] ХХК-ийн 02-2141018-24-I30653 тоот мэдүүлгээр 2201.90.10 кодод ангилан “идэвхжүүлсэн хүчилтөрөгчтэй ус” гэж мэдүүлсэн барааны ангиллын кодын талаар санал ирүүлэх хүсэлтийг ирүүлснийг судалж үзэн “эм агуулаагүй бүтээгдэхүүн” гэсэн сертификат, “хүнсний нэмэлт (a dietary supplement)” гэсэн шинжилгээний дүгнэлтийн дагуу 2106.90.11 кодод ангилах саналтай талаар 2024.09.10-ны өдрийн 02-2.1/157 тоот дотоод зурвасаар хариу өгсөн.<br>- ХХ-ээс Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс утаат болон электрон тамхины ангиллын кодтой холбоотой мэдээллийг авахаар ирүүлснийг уламжилсны дагуу мэдээлэл, тайлбарыг 2024.09.13-ны 02-2.1/163 тоот дотоод зуравсаар хүргүүлсэн.<br>- ХХ-ээс “Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулийн дагуу хувийн хэрэглээний зориулалтаар улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох эмийн ангиллын кодыг тодорхойлуулахаар ирүүлснийг судалж үзэн эдгээр эм нь хуульд нэрээр нь тодорхой зааж оруулсан, мөн хувийн хэрэглээний зориулалтаар нэвтрүүлэхийг хориглох заалт тул ангиллын кодыг тодорхойлох шаардлагагүй гэсэн хариуг 2024.09.27-ны 02-2.1/176 тоот дотоод зурвасаар өгсөн.<br><br>3.Тайлант хугацаанд дараах 3 аж ахуйн нэгжийн гаргасан гомдолтой холбоотой асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. Үүнд:<br>- “[redacted] ХХК нь БАУХ-ийн 2023.06.23-ны өдрийн 02-2/71 тоот БДШГ-т хүргүүлсэн "дотоод зурвас"-ыг хүчингүй болгуулах гомдол гаргасныг Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд "дотоод | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зурвас"-ыг гаалийн удирдах төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага хооронд албан ажлын зорилгоор санал, мэдээлэл солилцох, лавлагаа мэдээлэл гаргуулах, зөвлөмж, зөвлөгөө хүсэх, хүргүүлэх зэргээр хамтран ажиллахад ашигладаг, гадагш чиглээгүй, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон шийдвэр биш тул хүчингүй болгох шаардлагагүй гэсэн тайлбарыг БДШГ-т дотоод зурвасаар хүргүүлсэн. БДШГ-аас хариуг нэгтгэн 2024.02.14-ний өдрийн 02/508 тоот албан бичгээр хүргүүлсэн. Шүүх хуралд оролцох бэлтгэл ажлын хүрээнд тус компанийн 2020-2024 онуудад бүрдүүлэлт хийгдсэн зүрхний эмтэй стент, амплатцер, судас бөглөгч гэх бараануудын мэдүүлгийн мэдээллийн нэгтгэлийг хийсэн.<br>Мөн [redacted]ХХК-ийн импортолсон “зүрхний мэс заслын эмтэй стент” гэх бараатай холбоотой БЦТ-ийн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахаас татгалзсан шийдвэрийг хүчингүй болгуулахаар тус компани нь шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбоотойгоор хариу тайлбар болон БТКУС-ийн конвенци, Ерөнхий тайлбар дүрмийг хуулбарлан хүргүүлсэн.<br>“[redacted]ХК-ийн [redacted] тоот мэдүүлгээр “судас [redacted] гэж мэдүүлсэн, [redacted]тоот мэдүүлгээр “зүрхний мэс заслын амплатцер”-ыг Зүйл 90.18-д ангилан алдаатай бүрдүүлэлт хийгдсэнийг засварт буцаан кодыг засаж, “бичиг баримтын шалгалт хийгдсэн” төлөвтэй хүлээгдэж байгааг хүлээн зөвшөөрөлгүй шүүхэд хандсаны дагуу хариу тайлбарыг бэлтгэн хүргүүлсэн. Энэ 2 бараатай холбоотой ГХАХ-ээр дамжуулан ДГБ-ын Тариф, худалдааны нарийн бичгийн дарга нарын газарт амплатцер, судас бөглөгчийн талаарх мэдээллийг ангиллын зөвлөмж авах маягтын дагуу бөглөн хүргүүлсэн.<br>“[redacted]рах”, “[redacted]ХК-ийн Захиргааны хэргийн шүүхэд гаргасан 3 гомдолтой холбоотой асуудлаар БДШГ, ХХ, ХБГ-ын шүүх хуралд хариуцагчаар оролцож байгаа ГУБ болон ГУАБ нартай шүүх хурлын явцын талаар мэдээллээ нэгтгэх, цаашид хэрхэн оролцох асуудлаар санал солилцох 2024 оны 10-р сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан уулзалтаас үүрэг өгсөний дагуу 3 захиргааны хэргийн барааны ангилалтай холбоотой асуудлын явцын талаарх танилцуулгыг бэлтгэн хамтарсан хуралд танилцуулсан. “Санчир Ундрах” ХХК-ийн захиргааны 3 хэргийн шүүх хуралд нийт 13 удаа оролцож тухай бүрт нь барааны ангилалтай холбоотой тайлбарыг өгсөн.<br>Зөрчилтэй тэмцэх газраас “[redacted]ХХК-ийн гаргасан “[redacted]йн импортолсон “зүрхний титэм судасны эмтэй стент”, “зүрхний цоорхой бөглөгч амплатцер ([redacted]”“[redacted] гэх 3 нэр төрлийн барааны ангилалтай холбоотой асуудлаар дахин гомдол гаргасны дагуу Бүрдүүлэлтийн цахим төвийн бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУБ, ГУАБ нарт сургалт зохион байгуулах, чиглэл хүргүүлэх зэрэг арга хэмжээг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | авсан талаарх хариуг 2024.03.13-ны өдрийн 02-2.1/051 тоот дотоод зурвасаар өгсөн.<br>- “[redacted]” ХХК-аас 2024 оны 02-р сарын 19-ний өдрийн [redacted] мэдүүлгийн 9, 10, 12, 13 дугаар бараа болох [redacted] компанид үйлдвэрлэсэн [redacted] гэж мэдүүлсэн барааны ангиллын кодыг засах шаардлагыг хүлээн авахгүй талаар гомдол гаргасныг судалж үзэн тайлбарыг хүлээн авах боломжгүй талаар 2024.05.27-ны өдрийн 02-2.1/2053 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- [redacted] ХХК-ийн 2024.09.19-ний өдрийн [redacted] тоот мэдүүлгийн 1, 2 дахь “уян дурангийн бөөрний мэс заслын шээлгүүрийн стент гуурс [redacted]”, 10, 11 дэх “дурангийн мэс заслын цөсний сувгийн урсгуур гуурс (Cotton-leung biliary stent)”, 12 дахь “дурангийн мэс заслын нойр булчирхайн сувгийн урсгуур гуурс [redacted]”-ыг Зүйл 90.21-ийн хүний биед суулгах зориулалттай хэрэгсэл гэдэгт хамааруулан ангилсан БЦТ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 2024/490 тоот “Гаалийн улсын байцаагчийн шийдвэрт гаргасан гомдлыг хянасан тухай шийдвэр”-ийг хүлээн зөвшөөрөлгүй гомдол гаргасныг судалж үзэн шийдвэрийг хэвээр үлдээж, гомдлыг хангахаас татгалзсан талаарх хариуг 2024.10.03-ны өдрийн 02-2.1/4031 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | |
| 2 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэ-лээр | - | Монгол Улс, БНСУ хооронд ЭЗТХ байгуулах дараагийн хэлэлцээрийн бэлтгэл ажлыг хангахад оролцсон байна. | - Хэлэлцээний Барааны худалдааны бүлгийн бэлтгэл ажлын хуралд 2024 оны 01-р сарын 18, 06-р сарын 06-ны өдрүүдэд биеэр, 05-р сарын 17-ны өдөр онлайнаар оролцсон.<br>- МУ, БНСУ хооронд байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хоёр дахь шатны хэлэлцээний Барааны худалдааны бүлгийн хурал 2024 оны 05-р сарын 21-22-ны өдрүүдэд болж барааны худалдааны зах зээлд нэвтрэх эрх болон хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн. Хурлын үеэр Солонгосын талаас манай талаас хүргүүлсэн тарифын жагсаалтын зарим барааны ангиллын кодтой холбоотой тодруулж асуусан асуултуудад хариулт өгсөн. Хурлаар талууд эмзэг бараа бүтээгдэхүүний жагсаалтыг солилцох, эмзэг барааны жагсаалтдаа үндэслэн барааны жагсаалтын анхны саналаа солилцох, 2023 оны гадаад худалдааны статистикаа солилцохоор тохиролцсон.<br>- 3 дахь шатны хэлэлцээ 2024 оны 09 сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, Барааны худалдааны бүлгийн хуралдаанаар хэлэлцээрийн текст болон 2 талын тарифын жагсаалтын “Эмзэг бараа”-ны талаар санал солилцсон.<br>- 4 дэх шатны хэлэлцээ 2024 оны 11-р сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, Барааны худалдааны бүлгийн хэлэлцээрийн текстэд оруулах саналаа 2 тал хэлэлцэн, 1 зүйлийн заалтаас бусад хэсгээ ерөнхийд | 01.01-12.31 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нь тохиролцсон. Барааны тарифын жагсаалтын 2 дахь удаагийн саналын хувьд БНСУ-ын тал гарал үүслийн бүлэгтэйгээ харилцан ярилцаж саналаа өгнө гэж мэдэгдсэн. | | |
| 3 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэ-лээр | - | ДГБ-ын Уялдуулсан системийн хорооны хуралдаанд оролцох, холбогдох шийдвэрийг орчуулсан байна. | УСХ-ны 73 дугаар хуралдаанд 3-р сарын 06-15, 74 дүгээр хуралдаанд 9-р сарын 16-27-ны өдрүүдэд онлайнаар оролцсон. Хуралдаануудаар нийт 83 асуудлыг хэлэлцэхээр төлөвлөснөөс УС-ийн 2028 оны 14 нэмэлт, өөрчлөлт, Тайлбар бичигт оруулах 5 нэмэлт, өөрчлөлт, УС-ийн Тайлбар бичгийн 2022 оны хувилбарт оруулах 12 нэмэлт, өөрчлөлт, 19 барааны ангиллын санал дүгнэлт, 37 барааны ангиллын шийдвэрийг хэлэлцсэн. Тодорхой барааны 29 ангиллын шийдвэрийг гаргаснаас сонгон 5 барааны ангиллын шийдвэрийг орчуулан CAIS програмын УСХ-ны шийдвэрийн санд оруулж ГУБ нар гаалийн бүрдүүлэлтэд ашиглах боломжийг бүрдүүлсэн. | 01.01-12.31 | 88 |
| **Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх”** | | | | | | | |
| 1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | | - | | Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн барааны ангилалтай холбоотой заалтын хэрэгжилтийг 2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн байдлаар гарган ХХ-т, ХХХ-ийн Урьдчилсан шийдвэртэй холбоотой заалтын хэрэгжилтийг ЭУХ-т тус тус хүргүүлсэн. | 01.01-12.31 | 90 |
| 2 | Үүрэг даалгаврын биелэлт | | - | | 1. ГЕГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд БАҮХ-ээс оруулах арга хэмжээний санал өгсөн. Мөн ГЕГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний барааны ангиллын чиг үүрэгтэй хамааралтай 2 арга хэмжээний биелэлтийг гарган ЗУГ-т хүргүүлсэн. Хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Гаалийн захиргаа, дотоод ажлын системд оруулж батлуулсан.<br>2. Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэхтэй холбоотойгоор барааны ангиллын чиг үүрэгтэй холбоотой шалгуурын саналыг ХШҮДАГ-т 2 удаа өгсөн.<br>3. ЗУГ-т Гаалийн захиргаа, дотоод ажлын систем програмын “Үүрэг даалгавар” дэд цэсэнд тухайн нэгжид үүрэг даалгавар ирсэн үед програмд нэвтэрч ороход л анхааруулга гардаг болгох, ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон ажлын үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг болох удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг програмаар өгөх боломжтой болгох гэсэн 2 саналыг 2024.03.21-ний өдрийн 02-2.1/056 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн. | 01.01-12.31 | 90 |
| 3 | Ажлын цаг ашиглалт | | | | Жилийн хугацаанд ажлын цагийн хоцролт, тасалдалгүй ажилласан. | 01.01-12.31 | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | ДГБ болон ДХБ-аас боловсруулан гаргасан бодлогын бичиг баримтыг судалж, мэдлэг, чадвараа дээшлүүлнэ | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 | Мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна | - ДГБ-ын цахим хуудсанд гишүүний эрхээр нэвтрэн мэдээ, мэдээллийг авч ажиллаж байна. Мөн УС-ийн Жагсаалт, Тайлбар бичгийн цахим англи хувилбарыг ажилдаа байнга ашиглаж байна.<br>- УСХ-ны 73 дугаар хуралдаанд 3-р сарын 06-15, 74 дүгээр хуралдаанд 9-р сарын 16-27-ны өдрүүдэд онлайнаар оролцож, барааны ангиллын мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. | 01.01-12.31 | 95 |
| 2 | Гаалийн байгууллага болон бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад тухай бүр хамрагдана | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 95 | Сургалтад тухай бүр хамрагдсан байна | - Монгол-Японы гаалийн асуудлаар хамтран ажиллах хэлэлцээрийн хүрээнд Япон улсын Токио хотноо 2024 оны 02-р сарын 26-наас 03-р сарын 01-ний хооронд “Бүрдүүлэлтийн дараах шалгалт, барааны ангилал, үнэлгээ”-ний чиглэлээр зохион байгуулагдсан сургалтад хамрагдан барааны ангиллын хяналтыг хэрэгжүүлж байгаа дэд бүтэц, ангиллын урьдчилсан шийдвэр болон нэгж хооронд ангиллын мэдээлэл солилцдог туршлагаас суралцсан.<br>- ДГБ-аас 2024 оны 03-р сарын 25-29-ний өдрүүдэд ГЕГ-т зохион байгуулсан "Барааны гарал үүслийн үндэсний семинар" сэдэвт сургалтад оролцож, гарал үүслийн чиглэлээр мэдлэгээ дээшлүүлсэн.<br>- Мэдээллийн цагт нийт 21 удаа оролцож мэдлэгээ дээшлүүлсэн. | 01.01-12.31 | 95 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

БАРААНЫ АНГИЛАЛ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ............................ /Ц.УРАНТУУЛ/ 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

261

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЦЭГМИДИЙН УРАНТУУЛЫН
2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Барааны ангилал, үнэлгээний хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 2. "Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх"** | | | | | |
| 1 | Тарифын болон тарифын бус зохицуулалт, татварын чөлөөлөлттэй холбоотой эрх зүйн актын төсөлд барааны ангиллын талаас санал өгөх, барааны ангиллын кодыг тодорхойлох | 58 | 9 | 67 | |
| 2 | Шаардлагатай тохиолдолд үндэсний код, хэмжих нэгжид нэмэлт, өөрчлөлт оруулах | 57 | 8 | 65 | |
| 3 | ДГБ-ын Уялдуулсан системийн хорооны шийдвэрийг орчуулах, шийдвэрийн санг баяжуулах | 52 | 8 | 60 | |
| 4 | Харьяа гаалийн газар, хороодыг барааны ангилалтай холбоотой удирдамж чиглэлээр хангах, зөвлөгөө өгөх, асуудал хариуцсан ажилтнуудыг сургалт зохион байгуулах | 57 | 8 | 65 | |
| 5 | Их өгөгдлийг ашиглан хиймэл оюун ухааны тусламжтайгаар барааны ангиллын код тодорхойлоход лавлагаа болгон ашиглах платформын туршилт хийх бодлогын даалгавар боловсруулах | 52 | 8 | 60 | |
| **Зорилт 3. "Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх"** | | | | | |
| 1 | Барааны ангилалтай холбоотой ирүүлсэн санал, хүсэлт болон газар, хороодын даргын шийдвэрт гаргасан гомдол, маргааныг шийдвэрлэх, шийдвэрийн цахим санг баяжуулах | 58 | 9 | 67 | |
| 2 | Монгол Улс, БНСУ хооронд ЭЗТХ байгуулах дараагийн хэлэлцээний бэлтгэл ажлыг хангахад оролцох | 58 | 8 | 66 | |
| 3 | ДГБ-ын Уялдуулсан системийн хорооны хуралдаанд оролцох, холбогдох шийдвэрийг орчуулах | 53 | 9 | 62 | |
| **Зорилт 4."Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"** | | | | | |
| 1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 54 | 9 | 63 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Үүрэг даалгаврын биелэлт | 55 | 8 | 63 | |
| 3 | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | **64.3** | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | ДГБ болон ДХБ-аас боловсруулан гаргасан бодлогын бичиг баримтыг судалж, мэдлэг, чадвараа дээшлүүлэх | 95 | 14.2 | |
| 2 | Гаалийн байгууллага болон бусад байгууллагаас зохион байгуулах сургалтад тухай бүр хамрагдах | 95 | 14.2 | |
| **Дундаж оноо:** | | | **14.2** | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2 | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 3 | Хариуцлагатай байдал | 7 | |
| 4 | Дүн шинжилгээ хийх | 7 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар | | |
| **Дундаж оноо:** | | **7.0** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 |
| 2 | Багаар ажиллах | 8 |
| 3 | Харилцаа | 8 |
| | **Дундаж оноо:** | **8.0** |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 64.3 |

| | | |
|---|---|---|
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14.2 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Нэгжийн даргын үнэлгээ)* | 7 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **93.5** |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ /Ч.Чимгэрэл/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024.12.10
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Гаалийн улсын байцаагч ................................ /Ц.Урантуул/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.10
*(огноо)*

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ................................ /Г.Энхтайван/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

XII/20, 2024
*(огноо)*

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч ................................ /Ө.Тэгшээ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024.12.20
*(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Дарга ................................ /Р.Отгонжаргал/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

................................
*(огноо)*